

**“МОНГОЛ УЛСЫН ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ҮНДСЭН САНГИЙН ОРЛОГО, ҮНДСЭН
БОЛОН ГҮЙЛГЭЭНИЙ САНГИЙН ЗАРЛАГЫН 2016 ОНЫ ТӨСВИЙГ БАТЛАХ
ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2016 оны 04 дүгээр
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
 хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Д.Ганхуяг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд Улсын Их Хурлаас эрдэнэсийн сангийн үндсэн сангийн байнгын болон байнгын бус хэсэгт байвал зохих эрдэнэсийн нэр төрөл, хэмжээг тогтоох, үндсэн сангийн жилийн орлого, зарлагын хэмжээ болон гүйцэтгэлийн тайланг батлах, гүйлгээний сангаас жил бүр зарцуулах хэмжээг тогтоохоор заасныг үндэслэн Монголбанкнаас ирүүлсэн санал, түүнчлэн Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасны дагуу “Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн сан болон гүйлгээний сангийн зарлагын 2016 оны төсвийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтооолын төслийг Эдийн засгийн байнгын хороо боловсруулж, уг тогтооолын төслийг 2016 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр хаалттай хуралдаанаараа хэлэлцлээ.

Хэлэлцүүлгийн явцад гишүүдээс тодорхой санал гараагүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи тогтооолын төслийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36^{1.1} дахь хэсэгт “Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан ... бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.” гэж заасны дагуу “Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн сан болон гүйлгээний сангийн зарлагын 2016 оны төсвийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтооолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтооолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа

**ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Ц.БАЯРСАЙХАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар
 хот

Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2016 оны төсвийн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2, 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТӨГТООХ нь:

1.“Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2016 оны төсөв”-ийг хавсралтаар баталсугай.

Гарын үсэг